

10 АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛЫН ДААЛГАВАР**ХУВИЛБАР “А”**

Хугацаа: 80 минут

Нийт оноо: 100

Сурагчийн нэр:

Нэгдүгээр хэсэг 30 даалгавар 60 оноо

Хоёрдугаар хэсэг 10 даалгавар 40 оноо

1. Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтад орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралын хэлбэрийг юу гэх вэ? \ 2 оноо \

A. Нийгэм B. Улс C. Үндэстэн D. Төр E. Угсаатан

2. Нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог юу гэх вэ? \ 2 оноо \

A. Нийгмийн институт B. Нийгмийн элемент C. Нийгмийн бүтэц D. Нийгмийн статус

3. Шинэ Гвинейн Чамбули омгийнхны эрчүүд гэртээ сууж, нүүрээ будаж, эмэгтэйчүүдээ тоогдохыг хичээхийг хэвийн гэж үздэг бол манайд ийм эрэгтэйчүүдэд нэр хоч өгч, ад үзэн буруушаадаг. Энэ нь юутай холбоотой вэ? \ 2 оноо \

A. Гажуудал хувь хүнээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг

B. Гажуудал нийгмээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг

C. Гажуудал соёлоосоо хамаараад харьцангуй мөн чанартай байдаг

D. Дээрх бүгд зөв

4. Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу өгч буй үйл явцыг юу гэх вэ? \ 2 оноо \

A. Нийгмийн харилцаа B. Харилцан үйлдэл C. Бэлгэ тэмдэгтийн үйлдэл D. Нийгмийн үйлдэл

5. Монголын соёлын нэгдмэл шинжид аль нь хамаарахгүй вэ? \ 2 оноо \

A. Монгол аж төрөх ёс, ардын урлаг, хэл, төрт ёс, аман болон бичгийн соёл, хуримтлуулсан мэдлэг туршлага, ёс заншил B. “Би монгол хүн” хэмээн бахархах C. Могол, Казак, үндэсний соёлоос бүрддэг D. Бүгд хамаарна

6. Үндэсний соёл дэд соёлуудаас бүрддэг. Аль нь дэд соёл биш вэ? \ 2 оноо \

A. Үндэс угсаа B. Ардын C. Хот хөдөөгийн D. Ажил мэргэжлийн

7. Хүн бол бэлгэдлийн амьтан” бэлгэдлийн онолын үндэслэсэн эрдэмтэн хэн бэ? \ 2 оноо \

A. Ж. Мердок B. К.Клакон C. Э.Кассирер D. Э. Тайлор

8. Бүхий л соёлд нийтлэг байдаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг юу гэж нэрлэдэг вэ? \ 2 оноо \

A. Соёлын хэм хэмжээ B. Соёлын түгээмэл C. Соёлын нийтлэг D. Соёлын нэгдэл

9. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүний эрхийн суурь зарчмуудаас илүүцийг олно уу? \ 2 оноо \

A. Тэгш байдлыг хангах B. Хэм хэмжээг хангах

C. Ялгаварлан гадуурхахгүй байх D. Түгээмэл салшгүй байх

10. Хэн боолуудыг чөлөөлөн, бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг түүхэнд анх удаа тунхаглан шавар бортого дээр бичиж үлдээсэн бэ? \ 2 оноо \

A. Эртний Грекийн Софистууд B. Мартин Лютер Кинг C. Аугаа Сириус D. Элеанор Рузвельт

11. “Эрх чөлөөний харти” хэмээх баримт бичгийг хаана анхлан гаргасан бэ? \ 2 оноо \

A. Англи B. Франц C. Ром D. Грек

12. Эрх зүйн бүрэн бус чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ? \ 2 оноо \

A. 14-18 хүртэлх насны хүүхэд B. 18- аас дээш насны хүмүүс C. 7-14 хүртэлх насны

хүүхэд D. 7 хүртэлх насны хүүхэд E. 16 хүртэлх насны хүүхэд

13. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг эрх зүйн ямар чадамжтай вэ? \ 2 оноо \

A. Бүрэн чадамжтай B. Бүрэн бус чадамжтай C. Заримдаг чадамжтай D. Чадамжгүй

14. Төрийн орлого нь аль вэ? \ 2 оноо \

A. Цалин B. Зээлийн хүү C. Түрээсийн төлбөр D. Шууд бус татвар

15. Ихэнхдээ хувийн шалтгаанаар үүсдэг ажилгүйдэл бол... \ 2 оноо \

A. Шилжилтийн B. Улирлын C. Бүтцийн D. Мөчлөгийн

16. XX зууны эхээр гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшинд нөлөөлдөг болохыг судлан гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ хэдий их байна, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ төдий чинээ өндөр болдгийг тогтоосон эдийн засагч хэн бэ?

A. А.Смит В. Д.Рикардо С. Ж.Кейнс D. Фишер

17. Инфляцийн үед хэн хожих вэ? \2 оноо\

A. Төрийн албан хаагчид В.Банкинд хадгаламжтай хүмүүс
C. Банкнаас зээл авсан хувь хүн D. Өр зээлээ төлж байгаа хүмүүс

18. Ажилгүйдэл 1 % өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2.5% буурдаг болохыг баталсан эрдэмтэн нь хэн бэ? \2 оноо \

A. Оукен В. Лоренц С. Дуо Джонсон D. А. Лаффер

19. Төр нь хүний эрхийг хамгаалах үүрэгтэй тул иргэдэд төрийн бүх үйл ажиллагааг нээлттэй байхыг шаарддаг. Ардчилсан нийгэмд төрийн үйл ажиллагаа нээлттэй байснаар иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авлига, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх нь ардчиллын ямар зарчим бэ? \2 оноо \

A. Зөвшилцлийн зарчим В. Хууль дээдлэх зарчим
C. Шударга байх зарчим D. Нээлттэй зарчим E. Цөөнхийг хүндэтгэх зарчим

20. Эрх зүйт төрийн төлөө” “ Ардчилал бидний зорилт” “Хүнд суртлын аппаратыг устгая” “ Хүний эрхийг дээдлэе” гэх мэт уриа лоозон хэдэн оны хувьсгалд гарсан бэ? \2 оноо \

A. 1911 он В. 1921 он С. 1990 он D. Аль нь ч биш

21. Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж, ойлголтыг цэгцэлсэн ба плюралист онолын төлөөлөгч хэн бэ? \2 оноо \

A. А. Смит В. Д.Рикардо С. Ж.Локк D. У.Ростоу E. Р. Даль

22. Монгол цэргийн чадвар цэнхэр дуулгатнуудад үлгэр жишээ болж байна гэж хэн хэлсэн бэ? /2 оноо/

A. Дэвид Шийрэр В. И.Бентам С. Бан Гим Мун D. Кофи Аннан

23. Аливаа төрд 3-н төрлийн эрх мэдэл оршдог гээд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хэмээн ангилсан байдаг эрдэмтнийг сонгоно уу? \2 оноо\

A. Д.Инстон В.Н.И.Б.Макисвелли С.Ш.Монтескье D.Ж.Локк

24. Засгийн газрын үйл ажиллагааны эрх зүйн баримт бичиг аль нь вэ? \2 оноо\

A. Тогтоол, захирамж В. Зарлиг С. Шийдвэр D. Уриалга

25. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыг юу гэдэг вэ? \2 оноо \

A. Дипломат ухаан В. Олон улсын харилцаа С. Гадаад бодлогын харилцаа
D. Олон улсын эрх зүйн харилцаа E. Хүмүүнлэгийн ухаан

26. Монгол улс гадаад бодлогынхоо хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан оныг олж тэмдэглэ. \2 оноо \

A. 2000 он В. 1916 он С. 1996 он D. 1992 он E. 2011 он

27. Монгол улс хоёр хөрштэйгээ харилцах харилцааны чиглэлүүдийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо \

A.Хамтын ажиллагааны В. Эдийн засгийн С. Соёлын D.Боловсролын E. Хүмүүнлэгийн

28. ОУХ-нд оролцогч улс бус оролцогчдоос илүүцийг олно уу. \2 оноо\

A. Тусгаар тогтносон улсууд В. Далай лам С. НҮБ D. Coco cola

29. Тухайн улсыг бүрэн бус хэмээн хүлээн зөвшөөрсөн хэлбэр аль нь вэ? \2 оноо\

A. де-факто В. де-юре

30. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсуудыг ямар улсын ангилалд багтах вэ? \2 оноо \

A. Их гүрэн В. Дунд улс С. Бага улс D. Буурай улс

2-р хэсгийн даалгавар

31. Зөв хариултыг сонгоно уу. \4 оноо \

1	Нийгмийн харилцан үйдлийн явцад хувь хүн бусдын үүргийг хүлээн авах замаар өөрийн “БИ нь бүрэлдэн бий болдог”	A	К. Маркс
---	---	---	----------

2	“Өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэхдээ хэрэглэж буй бэлгэ тэмдэг, худалдаа арилжаандаа хэрэглэж буй мөнгөний тогтолцоо, мэргэжлийн зүгээс дагаж мөрдөх горим журам гэх мэт зүйлс надаас, миний хэрэглээнээс үл хамааран оршдог”	B	Ж. Мид
3	“ Хүмүүс өөрсдийнхөө түүхийг бүтээж байдаг, яаж бодсоноороо бус, өөрсдөө сонгоогүй бөгөөд байж байсан, тэдэнд өгөгдсөн, өнгөрсөн үеэс дамжиж ирсэн нөхцөлд бүтээж байдаг”	C	Э. Дюркгейм
4	Нийгмийн институтын чиг үүргийг\ функц\ судална гэлэг нь түүний гүйцэтгэж буй үүрэг буюу үйлдлийн үр дүнд ямар үр дагавар бий болов гэдгийг судлахыг хэлнэ”	D	Р.Мертон

A. 1C, 2B, 3A, 4D B. 1B, 2C, 3A, 4C C. 1A, 2C, 3B, 4C D. 1B, 2A, 3C, 4D

32. Аль ч ард түмний түүх, соёл, угсаатны зүйд хөдөлмөрийн зэвсэг бүтээх, биеэ гоёх, цус холилдохыг хориглох, сексийн хязгаарлалт, бүжиг, спорт, шашны зан үйл, бэлэг өгөх, зочлох, оршуулах ёс заншил, хэл, боловсрол зэрэг 72 төрлийн нийтлэг шинж байдаг хэмээн тодорхойлсон эрдэмтэн аль нь вэ? \ 4 оноо \

A. Ж.Мёрдок B. У.Самнер C. Э.Тайлор D. Л.Уайт E. У.Ф.Осборн

33. Английн эрх чөлөөний тулгын чулуу гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд шүүхийн шийдвэргүйгээр улсын хуулиас гадуур хүнийг гэм буруутайд тооцож үл болох зарчмыг анхлан тунхагласан баримт бичгийг юу гэж нэрлэдэг вэ? \ 4 оноо \

A. Түгээмэл тунхаглал B. Эрх чөлөөний харти C. Хүний эрхэм чанар D. Хүний эрхийн суурь зарчим

34. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? \ 4 оноо \

1	Бэлгэ тэмдэг	A	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм.
2	Хэл	B	Хүмүүсийн зан төлвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэлнэ.
3	Үнэлэмж	C	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг хэлнэ.
4	Хэм хэмжээ	D	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.

A. 1D 2B 3C 4A B. 1C 2A 3D 4B C. 1A 2D 3C 4B D. 1A 2D 3B 4C

35. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол аль нь вэ? \ 4 оноо \

A. Хуулийг хэрэгжүүлэх, хууль сахиулах B. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
C. Хууль тогтоох, хууль сахиулах, шүүх D. Хууль тогтоох, шүүх, прокурор
E. Хууль боловсруулах, гүйцэтгэх, шүүх

36. Олон улсын харилцаан дахь ойлголтуудыг зөв харгалзуулна уу? \ 4 оноо \

1	Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах... бодлого баримтлана	A	Эдийн засгийн олон тулгуурт бүтэц
2	Эдийн засгийн судалгаа тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай бүтцийг бий болгоно	B	Транзит Монгол
3	Үндэсний сонирхлыг тусгасан зорилгуудыг тодорхойлох, бусад улс, олон улсын байгууллагад нөлөөлөх замаар тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	C	Эдийн засгийн аюулгүй байдал
4	Манай улсын төмөр замын тээвэр нь Ази, Европыг холбосон олон улсын тээврийн коридорын нэг болохын хувьд БНХАУ, ОХУ, Европ болон буцах чиглэлд дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх төмөр замын салбарын хөгжилд онцгой ач холбогдолтой	D	Улс төрийн гадаад бодлого

A. 1B, 2A, 3C, 4D B. 1B, 2C, 3A, 4D C. 1A, 2B, 3C, 4D D. C.1D, 2A, 3B, 4C

37. Тохиолдол шинжилнэ үү? \4 оноо \

Иргэн Т 2016 оны 5 сард өөрийн найз Ө-д сарын 6 хувийн хүүтэй 5 сая төгрөг зээлдүүлж, зээлийн гэрээ байгуулсан. Зээлдэгч Ө эхний 6 сар зээлийн хүүг үндсэн мөнгөний хамт гэрээний дагуу хугацаанд нь төлөөд явж байсан боловч, 7 дахь сараас эхлээд зээлийн хүүгээ төлж чадахгүй байдалд хүрчээ. Иргэн Т ба Ө-ийн хооронд байгуулсан гэрээ хүчинтэй юу?

А. Гэрээ хүчинтэй В. Гэрээ хүчингүй С. Гэрээний хугацаа дууссан D. Зав хариу алга

38. Ардчилалын зарчмуудыг зөв харгалзуулна уу? \4 оноо \

1	Иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авилга, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлдэг	A	Хууль дээдлэх зарчим
2	Улс төрийн намууд, бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам	B	Цөөнхийг хүндэтгэх зарчим
3	Нийгэмд хүн бүр хуулийн хүрээнд ажиллаж амьдрах үүрэгтэй.	C	Зөвшилцлийн зарчим
4	Олонх нь удирдан захирч цөөнхийн эрхийг хуулиар болон хуулийн байгууллагаар дамжуулан хамгаалдаг	D	Нээлттэй зарчим

A.1D 2C, 3A, 4B,В. 1D 2B, 3C, 4A C.1A 2B, 3C, 4D, D.1C 2D, 3A, 4B,

39. Зөв харгалзуулаарай \4 оноо \

1	Гомдол	A	Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт
2	Өргөдөл	B	Өөрт болон бусдад туогарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
3	хүсэлт	C	Байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр
4	Захиргааны шийдвэр буюу акт	D	Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт

A. 1A, 2B, 3D, 4C B. 1A, 2C,3B, 4D C. 1C, 2B, 3A, 4D D. 1D, 2A, 3B, 4C

1. 40. Зөв харгалзуулна уу. \4 оноо\

1	Олон тулгуурт байх	A	Сратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.
2	Прагматик байх	B	МУ-ийн үндэсний эрх ашиг аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтрах, гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.
3	Тэнцвэртэй байх	C	Энэ зарчим нь гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц боллоцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах

A. 1A, 2B, 3C B. 1A, 2C, 3B C. 1B, 2C, 3A D. 1B, 2A, 3C

Амжилт хүсье

**10 АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ
“А” ХУВИЛБАРЫН ТҮЛХҮҮР**

ДД	ЗӨВ ХАРИУЛТ	ОНОО
1	A	2
2	C	2
3	B	2
4	B	2
5	D	2
6	D	2
7	C	2
8	B	2
9	B	2
10	C	2
11	A	2
12	A	2
13	D	2
14	D	2
15	A	2
16	D	2
17	C	2
18	A	2
19	D	2
20	C	2
21	E	2
22	A	2
23	C	2
24	A	2
25	B	2
26	D	2
27	A	2
28	A	2
29	A	2
30	B	2
1-р хэсгийн оноо		60
2-р хэсэг		
31	B	4
32	A	4
33	B	4
34	C	4
35	B	4
36	A	4
37	A	4
38	A	4
39	A	4
40	C	4
2-р хэсгийн оноо		40
Нийт оноо		100

10 АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ**ХУВИЛБАР “В”**

Хугацаа: 80 минут

Нийт оноо: 100

Сурагчийн нэр:

Нэгдүгээр хэсэг 30 даалгавар 60 оноо

Хоёрдугаар хэсэг 10 даалгавар 40 оноо

1.Тухайн байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой, хэм хэмжээлэг шинжтэй зан үйлдлийн цогцыг юу гэж ойлгох вэ? \2 оноо \

- A. Нийгмийн статус B. Нийгмийн үүрэг C. Нийгмийн элемент D. Нийгмийн бүтэц

2. Шинэ Гвинейн Чамбули омгийнхны эрчүүд гэртээ сууж, нүүрээ будаж,эмэгтэйчүүддээ тоогдохыг хичээхийг хэвийн гэж үздэг бол манайд ийм эрэгтэйчүүдэд нэр хоч өгч,ад үзэн буруушаадаг. Энэ нь юутай холбоотой вэ? \2 оноо \

- A. Гажуудал хувь хүнээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг
B. Гажуудал нийгмээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг
C. Гажуудал соёлоосоо хамаараад харьцангуй мөн чанартай байдаг
D. Дээрх бүгд зөв

3. Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу өгч буй үйл явцыг юу гэх вэ? \2 оноо \

- A. Нийгмийн харилцаа B. Харилцан үйлдэл C. Бэлгэ тэмдэгтийн үйлдэл D. Нийгмийн үйлдэл

4.“Өөрийнөө санаа бодлыг илэрхийлэхдээ хэрэглэж буй бэлгэ тэмдэг, худалдаа арилжаандаа хэрэглэж буй мөнгөний тогтолцоо, мэргэжлийн зүгээс дагаж мөрдөх горим журам гэх мэт зүйлс надаас, миний хэрэглээнээс үл хамааран оршдог” гэсэн утгыг хэн хэлсэн бэ? \2 оноо \

- A. К.Маркс B. Ж.Г. Мид C. Э.Дюркгейм D. Т.Парсонс

5. Бүхий л соёлд нийтлэг байдаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг юу гэж нэрлэдэг вэ? \ 2 оноо \

- A.Соёлын хэм хэмжээ B. Соёлын түгээмэл C. Соёлын нийтлэг D. Соёлын нэгдэл

6. Соёл судлал нь зууны эхэн үед бие даасан шинжлэх ухаан болжээ. Тохирох хариуг дугуйлна уу? \ 2 оноо \

- A. XX B. XIX C. XXI D. IXX

7. Нийт хүн төрөлхтний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарыггэнэ. \2 оноо \

- A. Үнэлэмж B. Үнэлгээ C. Үнэлэмжийн баримжаа D. Үнэт зүйл

8. Үндэсний соёл дэд соёлуудаас бүрддэг. Аль нь дэд соёл биш вэ? \2 оноо \

- A. Үндэс угсаа B. Ардын C. Хот хөдөөгийн D. Ажил мэргэжлийн

9. Хүний эрхийн ойлголт хаана үүссэн бэ? \2 оноо \

- A. Итали B. Грек C. Ром D. Франц

10. 7 хүртэлх насны этгээд эрх зүйн ямар чадамжтай вэ? \2 оноо \

- A. Бүрэн чадамжтай B. Бүрэн бус чадамжтай C.Заримдаг чадамжтай D. Чадамжгүй

11. “ Эрх чөлөөний харти “ хэмээх баримт бичгийг хэдэн онд анхлан гаргасан бэ? \2 оноо \

- A. 1205 B. 1225 C. 1215 D. 1235

12. Иргэний эрх зүйн харилцааны бүрдэл хэсгийг нэрлэ. \2 оноо \

- A. Субъект B. Объект C. Агуулга D. Дээрхи бүгд

13. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүний эрхийн суурь зарчмуудаас илүүцийг ол. \ 2 оноо \
A.Тэгш байдлыг хангах B.Хэм хэмжээг хангах C.Ялгаварлан гадуурхахгүй байх D.Түгээмэл салшгүй байх

14. ААН-ийн эздийн орлого нь \2 оноо \

- A. Цалин B. Зээлийн хүү C. Түрээсийн төлбөр D. Ашиг

15. Ажилгүйдэл 1% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2.5% буурдаг болохыг баталсан эрдэмтэн нь хэн бэ? \2 оноо \
- A. Оукен B. Лоренц C. Дуо Джонсон D. А. Лаффер
16. Төрийн орлого нь аль вэ? \2 оноо \
- A. Цалин B. Зээлийн хүү C. Түрээсийн төлбөр D. Шууд бус татвар
17. Ихэнхдээ хувийн шалтгаанаар үүсдэг ажилгүйдэл бол... \2 оноо \
- A. Шилжилтийн B. Улирлын C. Бүтцийн D. Мөчлөгийн
18. Инфляцийн төрөлд хамаарахгүй ойлголтыг олно уу? \2 оноо \
- A. Мөлхөө инфляци B. Өсөх инфляци C. Цогио инфляци D. Гипер инфляци
19. Олон улсын хүний эрхийн өдөр хэзээ болдог вэ? \2 оноо \
- A. 12 сарын 08 B. 12 сарын 10 C. 12 сарын 29 D. 1 сарын 22
20. БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон нь аль үндсэн хуулийн талаар мэдээлж байна вэ? \2 оноо \
- A. 1924 он B. 1940 он C. 1960 D. 1992
21. Монгол улсын “Шинэ үндсэн хууль” хэдэн онд батлагдсан бэ? \2 оноо \
- A.1924.11.26 B.1940.06.30 C. 1960.11.30 D. 1992.07.27 E. 1992.01.13
22. Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж, ойлголтыг цэгцэлж өгсөн эрдэмтэн хэн бэ? \2 оноо \
- A. Р.Даль B. Д.Истон C. Г.Алмонд D. Макиавелли E. К.Поппер
23. Эрх зүйт төрийн төлөө” “ Ардчилал бидний зорилт” “Хүнд суртлын аппаратыг устгая” “ Хүний эрхийг дээдлэе” гэх мэт уриа лоозон хэдэн оны хувьсгалд гарсан бэ? \2 оноо \
- A. 1911 он B. 1921 он C. 1990 он D. Аль нь ч биш
24. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолыг хэн боловсруулсан вэ? \2 оноо \
- A. Ш.Монтескье B. Д.Истон C. Г.Алмонд D. Макиавелли E. К.Поппер
25. Монгол цэргийн чадвар цэнхэр дуулгатнуудад үлгэр жишээ болж байна гэж хэн хэлсэн бэ? \2 оноо \
- A. Дэвид Шийрэр B. И.Бентам C. Бан Гим Мун D. Кофи Аннан
26. НҮБ-ын аюулгүйн зөвлөлд 15-н гишүүн байдгаас 5 нь байнгын гишүүн орон байдаг. Зөв өгөгдлийг ол. \2 оноо \
- A. Япон, Итали, Франц, Англи, Орос
B. Турк, Итали, Франц, Англи, Орос
C. Солонгос, Монгол, Орос, Канад, Австри
D. Голланд, Швейцарь, Энэтхэг, Бельги, Канад
E. Их Британи, Америк, Орос, Франц, Хятад
27. Монгол улс 1961 он хүртэл олон улсын хүрээнд бүрэн тусгаар улс шиг байж чадахгүй, хүлээн зөвшөөрлийг нь итгэл хүлээлгэхгүй байгаад байсан нь улс оролцогчийн ямар хэлбэрийн талаар мэдээлж байна вэ? \2 оноо \
- A. De Jure B. Ad Hoc C. De Facto D. De integro
28. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсуудыг ямар улсын ангилалд багтах вэ? \2 оноо \
- A. Их гүрэн B. Дунд улс C. Бага улс D. Буурай улс
29. Монгол улс гадаад бодлогынхоо хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан оныг олж тэмдэглэ. \2 оноо \
- A. 2000 он B. 1916 он C. 1996 он D. 1992 он E. 2011 он
30. Монгол улс хоёр хөрштэйгээ харилцах харилцааны чиглэлүүдийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо \
- A.Хамтын ажиллагааны B. Эдийн засгийн C. Соёлын D.Боловсролын E. Хүмүүнлэгийн

2-р хэсгийн даалгавар

31. 13-15-р зууны үеийн Монголын нийгмийн давхраажилт биш вэ? \ 4 оноо \

- A. Алтан ургийн ноёд B. Жирийн малчин C. Гэрийн зарц D. Ажилчин анги

32. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? \ 4 оноо \

1	Бэлгэ тэмдэг	A	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм.
2	Хэл	B	Хүмүүсийн зан төлвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэлнэ.
3	Үнэлэмж	C	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг хэлнэ.
4	Хэм хэмжээ	D	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.

A.1D2B3C4A

B.1C2A3D4B

C.1A2D3C4B

D.1A2D3B4C

33. Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүний эрхийн суурь зарчмын аль нь вэ?\ 4 оноо \

- A. Хуваагдашгүй байх B. Харилцан хамааралтай байх C. Ялгаварлан гадуурхал байх D. Түгээмэл, салшгүй байх

34. $M > \frac{PQ}{T}$ томъёоллын үед эдийн засагт аль нөхцөл үүсэх вэ? \ 4 оноо \

- A. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж, мөнгө үнэ цэнээ алдаж, улмаар инфляци үүснэ.
 B. Мөнгөний хомсдол бий болж нийт эрэлт буурна.
 C. Мөнгөний тоо үйлдвэрлэсэн бараа үйлчилгээ тэнцэж, эдийн засаг тогтвортой байна.
 D. B ба C нөхцөл үүснэ.

35. Ардчилалын зарчмуудыг зөв харгалзуулна уу? \ 4 оноо \

1	Иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авилга, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлдэг	A	Хууль дээдлэх зарчим
2	Улс төрийн намууд, бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам	B	Цөөнхийг хүндэтгэх зарчим
3	Нийгэмд хүн бүр хуулийн хүрээнд ажиллаж амьдрах үүрэгтэй.	C	Зөвшилцлийн зарчим
4	Олонх нь удирдан захирч цөөнхийн эрхийг хуулиар болон хуулийн байгууллагаар дамжуулан хамгаалдаг	D	Нээлттэй зарчим

A. 1C 2D, 3A, 4B,

B. 1D 2C, 3A, 4B

C. 1A 2B, 3C, 4D,

D. 1C 2D, 3B, 4A,

36. Олон улсын харилцаанд оролцогчдыг үйл ажиллагааны хамрах хүрээ, түвшингээр нь хэрхэн ангилдаг вэ? \ 4 оноо \

- A. Дэлхийн B. Бүс нутгийн C. Үндэсний D. Дээрх бүгд

37. Дараах ажил үйлчилгээнээс алийг нь ДНБ –д тооцох, үл тооцохыг тэмдгээр ялгаж тайлбарлаарай. \ 4 оноо \

№	Жишээ	ДНБ-д тооцогдох эсэх	
		Тийм	Үгүй
1	Тухайн жилд үйлдвэрлэсэн боловч борлогдож амжаагүй бүтээгдэхүүний үнэ		
2	Тухайн жилд үйлдвэрлэсэн талхны үнэ		
3	Эцсийн хэрэглээнд зориулагдаагүй барааны үнэ		
4	Тухайн орны нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгөөр баригдсан үйлдвэрийн газруудын үйлдвэрлэсэн барааны үнэ		
5	Сүүдрийн эдийн засагт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний үнэ		

38. Зөв харгалзуулаарай. \ 4 оноо \

1	Зан үйлийг хянах, зохицуулах	A	Гэр бүл
2	Нийгмийн нэгдэл, нягтралыг хангах, дээд ариун нандин зүйлд итгэх	B	Төр засаг, хууль, шүүх, цагдаа, шашин
3	Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах	C	Шашин боловсрол
4	Нийгмийн шинэ гишүүнийг төрүүлэх	D	Эдийн засаг

A. 1C, 2B, 3D, 4A B. 1C, 2B, 3A, 4D C. 1B, 2C, 3A, 4D D. 1B, 2A, 3C, 4D

39. Баримт жишээ: “ Иргэн Д.Лхамжавын гаргасан гомдлын дагуу УИХ-аас батлан гаргасан зарим хууль нь Үндсэн хууль зөрчсөн болохыг хэд хэдэн удаа хэлэлцэн тогтоож Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргасан байна”. Цэцийн шийдвэрийн дагуу УИХ дээр хэлэлцүүлэг явагдсан байна.

Дээрх өгүүлэмжийг улс төрийн тогтолцооны үйл явц гэж үзвэл улс төрийн системийн бүдүүвчийн дагуу хамаарах үйл явдлуудыг оноон бичнэ үү. \ 4 оноо \

A. Оролт-Гомдол B. Гаралт-Шийдвэр C. Дээрх бүгд

40. Зөв харгалзуулаарай \4 оноо\

1	Гомдол	A	Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт
2	Өргөдөл	B	Өөрт болон бусдад тусгаарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
3	хүсэлт	B	Байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр
4	Захиргааны шийдвэр буюу акт	Г	Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт

Амжилт хүсье

10 АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН**АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ****“В” ХУВИЛБАРЫН ТҮЛХҮҮР**

ДҮД	ЗӨВ ХАРИУЛТ	ОНОО
1	B	2
2	B	2
3	B	2
4	C	2
5	B	2
6	A	2
7	A	2
8	D	2
9	B	2
10	D	2
11	C	2
12	D	2
13	B	2
14	D	2
15	A	2
16	D	2
17	A	2
18	B	2
19	B	2
20	C	2
21	E	2
22	A	2
23	C	2
24	A	2
25	A	2
26	E	2
27	C	2
28	B	2
29	D	2
30	A	2
1-р хэсгийн оноо		60
31	D	4
32	C	4
33	C	4
34	A	4
35	B	4
36	D	4
37	C	4
38	A	4
39	C	4
40	C	4
2-р хэсгийн оноо		40
Нийт оноо		100